

**ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬЯАТЫН ГАЗРЫН “АЛСЫН ХАРАА-2050” МОНГОЛ
УЛСЫН УРТ ХУГАЦААНЫ ХӨГЖЛИЙН БОДЛОГЫН 2021-2025 ОНЫ
ХЭРЭГЖИЛТЭД ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

2025 оны 10 дугаар сарын 03

Улаанбаатар хот

“Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг хангах хүрээнд 2021-2025 онд байгууллагад хамаарах нэмэлтээр 3 зорилт, 8 арга хэмжээг хэрэгжүүлсэнд Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолоор батлагдсан “Хяналт-шинжилгээ, үнэлгээ, байгууллагын үйл ажиллагаа, үр дүнг үнэлж дүгнэх журам”-ын дагуу хяналт-шинжилгээ, үнэлгээг хийлээ.

Дээрх 3 зорилт, 8 арга хэмжээнээс хэрэгжилтийн явц, зорилтот түвшин нь “үр дүнтэй” буюу 85 хувь түүнээс дээш 6 арга хэмжээ, “үр дүн хүлээгдэж байгаа” буюу 60-84 хувьтай 1 арга хэмжээ, “үр дүн хангалтгүй” буюу 30-59 хувьтай 1 арга хэмжээ тус бүрийн дундаж үнэлгээгээр 86.2 хувь үнэлэгдлээ.

(Хүснэгт 1.)

Алсын хараа-2050				
Бүгд		Эдийн засаг	Засаглал	Амар тайван, аюулгүй нийгэм
Зорилт		3	1	1
Арга хэмжээний тоо		8	2	4
ҮНЭЛГЭЭ	Үр дүнтэй (85-100%)	6	2	2
	Үр дүн хүлээгдэж байгаа (60-84%)	1	-	1
	Үр дүн хангалтгүй (30-59%)	1	-	1
	Үр дүн гараагүй (0-29%)	-	-	-
Ерөнхий дүн		86.2 хувь		

“Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн хувь (Хүснэгт 2.)

Д/д	Арга хэмжээ	Зорилт	Дундаж хувь
Дөрөв. ЭДИЙН ЗАСАГ			
1(6)	4.3.37. Биометрик мэдээллийн хяналт шалгалтын системийг бүрэн нэвтрүүлнэ.	4.3. Олон улсын санхүүгийн зах зээлтэй холбогдсон, олон тулгуурт,	90
2(7)	4.3.38. Их өгөгдлийн сангийн мэдээллийн нууцлал, кибер аюулгүй байдлыг хангана.		100

		хүртээмжтэй санхүүгийн системийг хөгжүүлнэ.	
Хэсгийн дундаж үнэлгээ			95
Тав. ЗАСАГЛАЛ			
3(12)	5.3.16. Төрийн байгууллагын албан хэрэг хөтлөлт, албан бичиг солилцооны үйл ажиллагааг цахим хэлбэрт бүрэн шилжүүлж, сүлжээг бий болгоно.	5.3. Хүний хөгжлийг дэмжсэн, үр дүн, үр нөлөөтэй цахим засаглалыг төлөвшүүлнэ.	100
4(13)	5.3.21. Мэдээллийн нэгдсэн сангаар дамжуулан төрийн байгууллагын үйлчилгээнд цахим технологи нэвтрүүлж, хүнд суртал, авлига үүсэх эрсдэлээс хамгаална.		100
Хэсгийн дундаж үнэлгээ			100
Долоо. АМАР ТАЙВАН, АЮУЛГҮЙ НИЙГЭМ			
5(80)	7.5.6. Цахим мэдээллийн аюулгүй байдлын эмзэг байдлыг бууруулах, урьдчилан сэргийлэх, халдлагад хариу үйлдэл үзүүлэх чадавхыг бэхжүүлнэ,	7.5. Төр, иргэн, хувийн хэвшлийн мэдээллийн бүрэн бүтэн, нууцлагдсан, хүртээмжтэй байдлыг баталгаажуулж, өрсөлдөх чадвар бий болгоно.	100
6(81)	7.5.15. Өрсөлдөх чадвартай мэдээлэл, харилцаа холбооны систем, техник хэрэгсэл, программ хангамж, криптографийн үндэсний үйлдвэрлэл болон мэдээллийн аюулгүй байдлын шийдэл боловсруулах тогтолцоог бэхжүүлнэ.		100
7(82)	7.5.16. Тоон гарын үсгийн нийтийн түлхүүрийн дэд бүтцийг хөгжүүлж, тоон гарын үсгийг бүх нийтийн хэрэглээ болгох, тоон гарын үсэгт суурилсан цахим үйлчилгээний нууцлал, хамгаалалтыг хангана.		30
8(83)	7.5.18. Төрийн байгууллагуудын цахим халдлага зөрчилтэй тэмцэх компьютерын онцгой бэлэн байдлын баг байгуулж, мэдээллийн урсгалыг хянах замаар эмзэг байдлыг бууруулж, цахим форенסיкийн үндэсний төвийн үйл ажиллагааг өргөтгөн шинэчилнэ.		70
Хэсгийн дундаж үнэлгээ			75
Үнэлгээ			86.2

Дүгнэлт, санал

Байгууллагын хэмжээнд 2025 оны гуравдугаар улиралд “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг хангах хүрээнд нэмэлтээр 3 зорилт, 8 арга хэмжээг хяналтад ирүүлснээр биелэлт 86.2 хувьтай үнэлэгдлээ.

Дээрх нэмэлт арга хэмжээнээс “үр дүнтэй” болон “үр дүн хүлээгдэж байгаа” дараах арга хэмжээний биелэлтийг бүрэн хангаж ажиллах шаардлагатай. Үүнд:

Дөрөв. Эдийн засаг: 4.3.37. Биометрик мэдээллийн хяналт шалгалтын системийг бүрэн нэвтрүүлнэ.

Хэрэгжилт: Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуульд заасны дагуу Монгол Улсаас албадан гаргаж байгаа гадаадын иргэдийн хурууны хээг 2010 оноос авч эхэлсэн. Гадаадын иргэний бүртгэлийн дугаар олгох систем (RNSF)-д 2022 онд биометрик мэдээлэл хүлээн авахаар хөгжүүлэлт хийсэн. (90 хувь)

Долоо. Амар тайван, аюулгүй нийгэм: 7.5.18. Төрийн байгууллагуудын цахим халдлага зөрчилтэй тэмцэх компьютерын онцгой бэлэн байдлын баг байгуулж, мэдээллийн урсгалыг хянах замаар эмзэг байдлыг бууруулж, цахим форенסיкийн үндэсний төвийн үйл ажиллагааг өргөтгөн шинэчилнэ.

Хэрэгжилт: Мэдээллийн технологийн хэлтсийн кибер аюулгүй байдал хариуцсан ахлах мэргэжилтнийг байгууллагын даргын 2025 оны 03 дугаар 07-ны өдрийн Б/52 дугаар тушаалаар томилсон. Мэдээллийн аюулгүй байдлыг хангах, мэдээлэл алдагдахаас урьдчилан сэргийлэх зорилгоор 2025 онд Data Loss Prevention, Azure технологийг байгууллагын үйл ажиллагаанд нэвтрүүлэв.

Дорноговь аймгийн Замын-Үүд сумын Засаг даргын дэмжлэгтэйгээр Microsoft 365 E5 оффисын программын 130 ширхэг лиценз, Zscaler 50 ширхэг хэрэглэгчийн лицензийг тус тус орон нутгийн төсвийн хөрөнгөөр худалдан авч, Microsoft 365-ийн Data Loss Prevention (DLP) буюу байгууллагын мэдрэмтгий өгөгдлийг (sensitive data) хамгаалж, мэдээллийн алдаатай эсвэл зөвшөөрөлгүйгээр алдагдах байдлыг хянах, зогсоох зорилготой аюулгүй байдлын функцийг тохирууллаа. (70 хувь)

Мөн “үр дүн хангалтгүй” дараах арга хэмжээний хэрэгжилтийг эрчимжүүлэх шаардлагатай. Үүнд:

Долоо. Амар тайван, аюулгүй нийгэм: 7.5.16. Тоон гарын үсгийн нийтийн түлхүүрийн дэд бүтцийг хөгжүүлж, тоон гарын үсгийг бүх нийтийн хэрэглээ болгох, тоон гарын үсэгт суурилсан цахим үйлчилгээний нууцлал, хамгаалалтыг хангана.

Хэрэгжилт: Тус байгууллагад бүртгэлтэй олон улсын болон гадаад улсын төрийн бус байгууллагын салбар төлөөлөгчийн газруудыг тоон гарын үсэг ашиглах боломжоор хангах зорилгоор холбогдох мэдээллийг төрийн мэдээлэл солилцооны ХҮР системд дамжуулах сервисийг хөгжүүлж, FS100115_NonGovernmentHeadInfo дугаартай сервисийн мэдээллийг 08 дугаар сарын 27-ны өдөр тоон гарын үсэг олгогч байгууллагуудад цахим шуудангаар хүргүүлсэн. (30 хувь)

Цаашид дээрх арга хэмжээний хэрэгжилтийг эрчимжүүлж, чанарт анхаарч, үр дүнг бууруулахгүй ажиллахыг санал болгож байна.

--oo0oo--